

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2019 оны 02 сарын 27-ны өдөр

Сайншанд

1. Дорнговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь Хатанбулаг сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бокир, усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Хатанбулаг сумын төвийн төвлөрсөн дулаан, цэвэр, бокир, усны шугам сүлжээ, барилга байгууламжийн зураг төсөв боловсруулна.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14-16 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ. Үүнд:

3.1. Компанийн танилцуулга

3.2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар

3.3. Шаардлагатай тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар Үүнд:

- 1.2.1. 1-10 хүртэл давхар барилга байгууламжийн барилга архитектур, орчны ерөнхий төлөвлөгөө, тохижилт, өндөржилт, барилга бүтэээцийн зураг төсөл, барилгын зохион байгуулалтын зураг төсөл (БЗБТ, АГТ, УЗБТ)- / 3T.8.1, 3T-3.1, 3T-8.1
- 1.2.4. Дотор усан хангамж, ариутгах татуурга, халаалт, салхивч агаар сэлгэлт, хөргөлтийн систем, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл- / 3T-6.1, 3T-6.2, 3T-7.1, 3T-7.2/
- 1.2.5. Дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамж, гадна салбар шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн зураг төсөл (10 кВ хүртэл)- / 3T-6.3, 3T-6.4, 3T-7.3, 3T-7.4/
- 1.3.1 Дулааны гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- 1.3.2 Усанхангамж, ариутгах татуургын гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- 1.3.3 Цахилгаан дамжуулах гол шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг
- 1.3.5 Усны барилга байгууламжийн зураг төсөл

3.4. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор/

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор /

3.6. Сүүлийн 2 жил буюу 2018, 2017 онуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт нотариатаар баталгаажуулах

3.7. Татварын байгууллагын тодорхойлолт /Тендер зарласан өдрөөс хойших огноогоор, татварын өр буюу дутуу үлдэгдэлгүй байх/;

4. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт хүснэгтээр ирүүлэх /2017, 2018 оны аль нэг жилд хийж гүйцэтгэсэн ижил төстэй гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсхүл захиалагч байгууллагын тодорхойлолтыг хавсаргах/

5. Голлох мэргэжилтэн буюу төслийн удирдагчийн /мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар зэрэг нотлох баримтыг ирүүлэх/

6. Гадаадын хуулийн этгээд оролцож үл болно.

7. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2019 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 10:00 цаг хүртэл дор дурдсан хаягаар авч болох бөгөөд 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 11:00 цагаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn хаягаар нэвтэрч мэдүүлгээ ирүүлнэ үү.

